

**ХӨДӨЛМӨР ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТОГТОЛЦООНЫ ГАДААД АЖИЛЧИН
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ОНООНЫ ТОГТОЛЦОО
ХЭРЭГЖИХ ТУХАЙ ЗАРЛАЛ**

БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт хөдөлмөрийн яам, Монгол улсын Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамдын хамтарсан 2021 оны Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн тогтолцооны дагуу гадаад ажилчин сонгон шалгаруулах “Онооны тогтолцоо” хэрэгжүүлэх төлөвлөгөө дараахитай адил байна.

“Онооны тогтолцоо” нь солонгос хэлний мэдлэгээс гадна эрүүл мэндийн суурь нөхцөл (өнгө ялгах чадвар, нурууны диск, гар сарвууны бүрэн байдал зэрэг нь хөдөлмөр эрхлэхэд бэрхшээлтэй гэж үзэх буюу **тэнцэхгүй**), ур чадварын, ажил үүргийн чадвар гэх мэтээр хүн бүрийн чадвар дээр нэгдсэн үнэлгээ хийх арга юм.

Онооны тогтолцооны **1 дэх шалгалт (СХТТШ)** -д салбар тус бүр нийт авах боломжит оноо (100 онооноос 50 оноо)-ноос дээш оноо авсан иргэдээс өндөр оноо авсан дарааллаар сонгоно. Ингэхдээ төлөвлөсөн хүний тооноос 1.1 дахин их тоонд багтаан 1 дэх шалгалтад тэнцүүлнэ.

1 дэх шалгалтад тэнцсэн иргэдээс 2 дахь шалгалт (ур чадварын шалгалт, мэргэжлийн чадварын үнэлгээ) -ыг авсаны дараа салбар тус бүр нийт авах боломжит оноо (100 онооноос 60 оноо)-ноос дээш оноо авсан иргэдээс өндөр оноо авсан дарааллаар **1,2 дахь шалгалтын дүнг нэгтгэн өндөр онооны дарааллаар сонгож авахаар төлөвлөсөн хүний тоонд багтааж эцсийн байдлаар шалгаруулна.**

2 дахь шалгалт буюу мэргэжлийн ур чадварын үнэлгээнд мэргэжлийн сургалтад хамрагдсан байдал, мэргэжлийн үнэмлэх, ажлын туршлага байгаа бол нотлох бичиг баримтыг хавсаргах хэрэгтэй ба ур чадварын шалгалтад заавал хамрагдана. Хамрагдаагүй бол эцсийн шалгаруулалтаас хасагдахыг анхаарна уу.

Өнгө ялгах чадвартай эсэхээ хувь хүн урьдчилан шалгасны дараа бүртгүүлэх эсэх шийдвэрээ гаргана уу.

Мөн **Ур чадварын шалгалт (УЧШ)**-ын явцад **өнгө ялгах чадваргүй нь батлагдвал** салбар бүрийн онцлогыг харгалзан **эрүүл мэндийн хувьд нийцэхгүй буюу тухайн салбарт хөдөлмөр эрхлэхэд бэрхшээлтэй гэж шалгалтын комисс дүгнэсэн тохиолдолд эцсийн шатны шалгаруулалтаас хасна.**

Санаачлагч: БНСУ-ын Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн яам
 Зохион байгуулагч: БНСУ-ын Аж үйлдвэр хүний нөөцийн хэрэг эрхлэх газар
 Хамтран зохион байгуулагч : Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар

Гадаадаас ажиллах хүч сонгон шалгаруулах ОНООНЫ СИСТЕМ гэж юу вэ?

1. Зорилго

- Одоогоор хүчинтэй байгаа ажил хайгчдын хувьд Солонгос хэлний чадвараар сонгогдож байршсан байгаа нь ажил гүйцэтгэх чадвар, бие бялдар, ажлын туршлага зэрэг нь ажил олгогчын олон талын шаардлагыг хангаж чадахгүй байгаа бөгөөд энэ нь бодит байдал дээр Солонгос хэлний мэдлэг бага ч гэсэн ажил мэргэжлийн ур чадвартай, тогтвортой ажиллаж чадах гадаад иргэд сонгогдон явж чадахгүй хязгаарлагдаж байна.
- Эдгээр бэрхшээлийг давж Солонгос хэлний болон бие бялдар, ур чадвар, ажлын туршлага гэх мэт хүн тус бүрийн чадварт нэгдсэн үнэлгээ хийх аргаар сонгон шалгаруулах тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн.
- Ажил хайж буй иргэний солонгос хэлний чадвар, ур чадварын шалгалтын оноо, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв (МСҮТ) төгссөн байдал, мэргэжлийн үнэмлэх, боловсролын зэрэг, ажлын туршлага гэх мэт мэдээллээр ажил олгогчийг хангана.
- Мөн Солонгос Улсад ажиллах сонирхолтой иргэн солонгос хэлний чадвар хангалттай биш ч гэсэн ур чадварын өндөр оноотой, ажлын туршлагатай тогтвортой ажиллах иргэнийг Солонгос улсад ажиллах боломжийг нэмэгдүүлнэ.

2. Бүтэц

° **Сонгон шалгаруулах дараалал :**

① 1дэх шалгалт (СХТТШ) → ② 2дахь шалгалт (ур чадварын шалгалт + мэргэжлийн ур чадварын үнэлгээ) → ③ үнэлгээний оноог нэгтгэнэ.

° **Эцсийн байдлаар хариу гаргах:**

Нэгтгэсэн нийт оноогоор өндөр оноо авсан дарааллаар эцсийн байдлаар шалгаруулна.

< Үнэлгээний оноо хуваарилалт >

| Салбар | Нийт оноо | СХТТШ | Ур чадвар | Мэргэжлийн ур чадварын үнэлгээ (нэмэлт оноо) | | |
|------------|-----------|----------|-----------|--|--|--------------------------------------|
| | | | | 1-ээс дээш жил аж үйлдвэрт ажилласан туршлагатай | 120-иос дээш цагийн МСҮТ, дээд сургууль төгссөн /аж үйлдвэрийн чиглэл/ | 1-ээс дээш мэргэжлийн үнэмлэхтэй бол |
| Аж үйлдвэр | 200 оноо | 100 оноо | 100 оноо | 3 оноо | 1 оноо | 1 оноо |

3. 1 дэх шалгалт (СХТТШ)

- ° Шалгалтын цаг хугацаа : Нийт 50 минутаас унших 20 асуулт 25 минут, сонсох 20 асуулт 25 минут. Тухайн нөхцөл байдлаас хамаарч өөрчлөгдөж болно.
- ° 4 сонголттой даалгавар бүхий унших, сонсох тест нь үргэлжлэн явагдана.
- ° Онооны хуваарилалт : 100 оноо (1 асуулт тус бүрт 2,5 оноо)
- ° **1 дэх шалгалт (СХТТШ)** -д салбар тус бүр нийт авах боломжит оноо (100 онооноос 50 оноо)-ноос дээш оноо авсан иргэдээс өндөр оноо авсан дарааллаар салбар тус бүр төлөвлөсөн хүний тооноос 1.1 дахин их тоонд багтаан тэнцүүлнэ

4. 2 дахь шалгалт (ур чадвар + мэргэжлийн ур чадварын үнэлгээ)

① Ур чадварын шалгалт

- ° Авах салбар : **Аж үйлдвэр**
- ° Биеийн тамир, ярилцлага, суурь ур чадвар гэсэн 3 хэсгээс бүрдэнэ.

| Салбар | Нийт оноо | Ур чадварын шалгалт | | |
|------------|-----------|---------------------|-----------|-----------------|
| | | Биеийн тамир | Ярилцлага | Суурь ур чадвар |
| Аж үйлдвэр | 100 оноо | 30 оноо | 30 оноо | 40 оноо |

Жич: Ур чадварын шалгалтын нийт оноо нь 60 хувьд хүрэхгүй бол эцсийн шалгаруулалтаас хасагдана.

② Мэргэжлийн ур чадварын үнэлгээ

- ° Хамрах хүрээ: 1 дэх шалгалт (СХТТШ)-ад тэнцсэн буюу аж үйлдвэрийн салбарт ажиллах ажлын туршлагатай, МСҮТ-ийн гэрчилгээтэй, улсын мэргэжлийн үнэмлэх, эсвэл дээд сургууль төгссөн дипломтой иргэн;
- ° Бүрдүүлэх бичиг баримт: Өргөдөл (өргөдлийн маягтыг бүртгэл хийх газраас авах буюу цахим хуудаснаас татаж авна)
 - * Аж үйлдвэрийн салбарт хамаарах ажлын туршлага, ажлын газрын тодорхойлолт, МСҮТ төгссөн гэрчилгээ, мэргэжлийн үнэмлэх, дээд сургууль төгссөн диплом г.м.
 - * Дээрх нотлох баримт байхгүй бол өгөх шаардлагагүй.
- ° Бүртгэлийн сүүлийн өдөр хүртэл бичиг баримтыг хүлээж авна.
- ° Мэргэжлийн ур чадварын үнэлгээнд хуурамч материал бүрдүүлж өгсөн нь нотлогдвол шалгалтыг хүчингүйд тооцож шалгалт өгөх эрхийг 4 жилээр хасна. (хуурамч бичиг баримт бүрдүүлсэн иргэнийг зохих хууль хяналтын байгууллагад мэдэгдэнэ)

I . 1 дэх шалгалт (СХТТШ)

- 2021 оны 6-р сарын 21-нд зарлана.
- 1 дэх шалгалт буюу СХТТШ-ын бүртгэл: 2021 оны 6 сарын 29-нээс 30-ны өдрүүдэд явагдана.
- Шалгалт өгөх хуваарийг 2021 оны 7-р сарын 16 -нд зарлана.
- СХТТШ шалгалт 2021 оны 7-р сарын 26-наас 9-р сарын 17-ны өдрүүдэд явагдана.
- **1 дэх шалгалт буюу СХТТШ**-нд тэнцсэн иргэдийн нэрийг 2021 оны 9-р сарын 23 -нд зарлана.

1. 1 дэх шалгалт (СХТТШ)-аас сонгож авах хүний тоо : 744 хүн

(Үнэлгээний оноо 100 байна)

- Эцсийн шалгаруулалтаас сонгож авах хүний тоо 676

※ **1 дэх шалгалт** (СХТТШ) -д нийт авах боломжит 100 онооноос 50 оноо (нийт авах боломжит оноог 200%-д хувилах тохиолдолд 50 оноо нь **95 оноотой ижил байна**.)-ноос дээш оноо авсан иргэдээс өндөр оноо авсан дарааллаар сонгоно. Ингэхдээ төлөвлөсөн хүний тооноос 1.1 дахин их тоонд багтаан сонгож авна.

2. Аж үйлдвэрийн салбарын суурь ур чадварын дэд салбарыг сонгоно.

а. Бүртгэлийн анкет бөглөхдөө дэд салбараас заавал нэгийг сонгож бөглөнө.

1. Угсрах 2. Хэмжих 3. Холбох энэ 3-аас аль нэгийг сонгоно.

(шалгалтын дараа сонголтыг өөрчлөх боломжгүй)

б. Давхар бүртгүүлэх боломжгүй.

3. Тавигдах шаардлага:

а. 18- 39 настай байх (1981 оны 6-р сарын 30-наас

2003 оны 6-р сарын 29-ны өдрийн хооронд төрсөн);

б. Хорих ялтай эсвэл түүнээс илүү хүнд ялтай гэмт хэрэгт холбогдоогүй байх;

в. БНСУ-аас албадан гаргах буюу тус улсыг орхин явах захирамж гаргуулж байгаагүй байх;

г. Монгол Улсаас гарах эрхээ хязгаарлуулаагүй байх;

д. Өнгө ялгах чадвартай байх (нурууны үений диск, гарын сарвуу дутуу тохиолдолд хэлний шалгалтанд орж болох хэдий ч 2 дахь шалгалтад ажил үүрэг гүйцэтгэх чадамжгүй гэж үзэн хасах болно);

е. Мэргэжлийн бус ажилчны Е-9, усан онгоцны ажлын Е-10 визээр БНСУ-д 5 болон түүнээс дээш жил ажиллаагүй байх;

4. СХТТШ -ын бүртгэл

| | | |
|----|--|--|
| 1. | Цахим бүртгэл явагдах хугацаа | 2021 оны 6-р сарын 29-ний өдрийн 09:00 ~ 18:00 цаг 2021 оны 6-р сарын 30-ний өдрийн 09:00 ~ 18:00 цаг |
| 2. | Бүртгүүлэх, дугаар олгох системийн нэр | http://solongos.hudulmur-halamj.gov.mn |
| 3. | Системд нэвтрэх | Ухаалаг гар утас, компьютер, таблет зэргээс системд нэвтрэнэ. |

① Цахим бүртгэлийн дугаар олгох систем <http://solongos.hudulmur-halamj.gov.mn> –д нэвтэрч өөрийн мэдээллийг бүртгүүлнэ.

Бүртгүүлэхэд:

- Системд бүртгүүлэх заавар, зөвлөмжийг холбогдох мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.
- Та зөвхөн өөрийн оршин суугаа аймаг, дүүргийг сонгоно.
- Өөрийн байгаа газраас Ухаалаг гар утас, компьютер, таблет зэргээс холбогдон нэвтрэх боломжтой.
- Өөрийн мэдээллийг буруу оруулсан тохиолдолд дахин бүртгүүлэх боломжгүй тул анхааралтай уншиж бөглөнө.

- Системийн цонхонд бүртгүүлж дуусахад “ТА БҮРТГЭГДЛЭЭ. Бүртгэлийн 50.....” гэж гарч ирнэ. Энэ мэдээллийг өөртөө хадгалж авна.
- Та, бүртгүүлж амжаагүй бол 2022 оны бүртгэлд хамрагдах боломжтой.

② Гадаад паспорт (иргэний үнэмлэх)-ын хуулбарын файл

- ※ Овог нэр монголоор бичигдсэн байна.
- ※ СХТТШ-д бүртгүүлэх үеийн хувийн мэдээлэл гадаад паспортаас бага зэрэг зөрсөн тохиолдолд БНСУ-ын хилээр нэвтрэх боломжгүй болох ба энэ нь бүртгүүлэгчийн хариуцлага учраас бүртгүүлэхээсээ өмнө гадаад паспорт авахыг зөвлөж байна.
- ※ Бүртгүүлэх үед тэмдэглэсэн англи овог нэр, төрсөн он сар өдөр, хүйс, цээж зураг зэрэг нь дараа нь тухайн иргэнийг солонгост ажилд зуучлахад ашиглагдах бөгөөд өөрчилж солих боломжгүй байдаг.

③ Гадаад паспортын зураг буюу цагаан дэвсгэр дээр бараан хувцастай (хэмжээ 3,5*4,5см), 1 хувь буюу цахимаар оруулна. (сүүлийн 3 сарын дотор) авахуулсан байна.

④ Бүртгэлийн хураамж: 24 ам.доллартай тэнцэх Төрийн банкны тухайн өдрийн зарласан /зарах ханшаар/ монгол төгрөгөөр тооцож тушаана.

- ※ Бүртгэлийн хугацаанд бүртгэл цуцлуулах зайлшгүй шаардлага гарвал бүртгэлийн хугацаанд **(2021 оны 6-р сарын 29, 30, 7-р сарын 1, 2, 5-ны өдрүүдэд)** багтаан ХХҮЕГ-д бичгээр хүсэлт гарган хураамжийг буцаан авах боломжтой. **(Дээрх хугацаанд хүсэлт гаргаагүй тохиолдолд буцаан олгох боломжгүй.)**

⑤ Шалгалт авах газар ба хуваарь зарлах тухай

а. Иргэдийн шалгалт өгөх хуваарийг 2021 оны 7-р сарын 16-нд зарлана.

б. Мэдээллийн хэрэгсэл:

- ① ХХҮЕГ-ын цахим хуудас (hudulmur-halamj.gov.mn)
- ② БНСУ-ын АҮХНХЭГ-ын төлөөлөгчийн газрын цахим хуудас(monkor.net)
- ③ Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо СХТТШ-ын цахим хуудас(epstopik.hrdkorea.or.kr)

6. Шалгалт явагдах хугацаа, цагийн хуваарь:

※ 2021 оны 7 дугаар сарын 26-аас 9-р дүгээр сарын 17-ны өдрүүдэд ХХҮЕГ-ын 2 давхарт шалгалтын танхимд авахаар төлөвлөж байна.

| Ээлж | Шалгалт авах комиссын гишүүдийн хурал | Шалгалтын заавар | Шалгалтын цагийн хуваарь | |
|----------|---------------------------------------|------------------|--------------------------|-----------------|
| | | | Унших 25 минут | Сонсох 25 минут |
| 1-р ээлж | 09:20-09:30 | 09:30-10:00 | 10:00-10:25 | 10:25-10:50 |
| 2-р ээлж | 10:50-11:00 | 11:00-11:30 | 11:30-11:55 | 11:55-12:20 |
| 3-р ээлж | 13:20-13:30 | 13:30-14:00 | 14:00-14:25 | 14:25-14:50 |
| 4-р ээлж | 14:50-15:00 | 15:00-15:30 | 15:30-15:55 | 15:55-16:20 |

※ Иргэд шалгалт өгөхөөр ирэхдээ:

09:00 (1-р ээлж),

10:30 (2-р ээлж),

13:00 (3-р ээлж),

14:30 (4-р ээлж) цагуудыг ягштал баримталж ирнэ үү.

※ Шалгалтын хугацаа 1 өдөрт авах ээлж болон хүний тоо нь тухайн үеийн нөхцөл байдлаас хамаарч өөрчлөлт орж болзошгүй.

7. Шалгалтын бүтэц:

| Бүтэц | Асуулт | Аж үйлдвэр | Үргэлжлэх хугацаа |
|--------|-----------|------------|-------------------|
| Унших | 20 асуулт | 100 оноо | 25минут |
| Сонсох | 20 асуулт | | 25минут |
| Нийт | 40 асуулт | 100 оноо | 50минут |

※ Шалгалтын цаг ба асуултын тоонд тухайн үеийн нөхцөл байдлаас хамаарч өөрчлөлт орж болно.

Тухайн шалгалт өгөх өдөр гадаад паспорт эсвэл иргэний үнэмлэх, эсвэл ТҮЦ машинаас авсан цахим үнэмлэхний лавлагааг бүртгэлд хуулбар хийсэн бичиг баримтыг эх хувиар нь авч ирнэ.

※ Бичиг баримтаа авч ирээгүй бол шалгалтад оруулахгүй.

8. СХТТШ (1 дэх шалгалт) -д тэнцсэн хариуг 2021 оны 9-р сарын 23-нд www.hudulmur-halami.gov.mn, monkor.net, (epstopik.hrdkorea.or.kr) цахим хуудсуудаар зарлана.

II . 2 дахь шалгалт (Ур чадварын ба Мэргэжлийн ур чадварын үнэлгээ УЧШ)

- Мэргэжлийн ур чадварын үнэлгээнд орох иргэнийг 2021 оны 9-р сарын 28-30-ны хооронд бүртгэнэ.
- 2021 оны 10-р сарын 1-нд ур чадварын шалгалтын (УЧШ) хуваарийг зарлана.
- 2021 оны 10-р сарын 9-10-ны хооронд мэргэжлийн ур чадвар (МУЧ)-ын бичиг баримтын үнэлгээ хийнэ.
- 2021 оны 10-р сарын 22-нд эцсийн хариуг зарлана.

1. Мэргэжлийн ур чадварын үнэлгээнд оруулах бичиг баримтыг өгөх:

- а. Солонгос хэлний шалгалтад тэнцсэн иргэн байна.
 - Солонгос хэлний шалгалтад тэнцэн аж үйлдвэрийн салбарт ажилласан, МСҮТ-д 120-иос дээш цагийн сургалтад хамрагдсан, дээд боловсролтой, мэргэжлийн үнэмлэхтэй иргэн,
 - Солонгос хэлний шалгалтад тэнцсэн иргэн нь ур чадварын шалгалтанд заавал хамрагдана. Тусдаа бүртгэл явагдахгүй. Харин мэргэжлийн ур чадварын (МУЧ) үнэлгээ хийлгэх иргэн нь бүртгэлийн хугацаанд бичиг баримтаа бүрдүүлж өгсөнөөр оноо нэмүүлэх боломжтой.
 - б. 2021 оны 9-р сарын 28-30-ны хооронд бүртгэнэ.
 - в. 1 дэх шалгалтад тэнцсэн иргэн тухайн дээрх бичиг баримтыг аймаг, дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, хэлтэс дээр эх хувийг авчирч скайнер хийлгэн бүртгүүлнэ.
 - г. Бүртгэлийн хураамж байхгүй.
 - д. Бүртгүүлэх үеийн бичиг баримт
 - ① Иргэний үнэмлэх, эсхүл гадаад паспорт (лавлагаа)
 - ② Мэргэжлийн ур чадварын үнэлгээний анкет, бусад нотлох баримт (маягтуудыг цахим хуудаснаас татаж авч бөглөнө.)
- ※ Ур чадварын шалгалтад ороогүй бол сонгон шалгаруулалтаас шууд хасагдана.

| Ангилал | Холбогдох бичиг баримт | Бичиг баримтын агуулга | Бусад |
|--------------------------|---|--|---|
| Ажлын туршлага | EPS системээс ажлын газрын тодорхойлолт (эх хувь) | www.eps.go.kr –хуудаснаас ажлын газрын тодорхойлолтыг хэвлэж авна. (зөвхөн Солонгост ажилласан туршлагыг зөвшөөрнө) | Хуулбараар бүртгүүлж шалгалт өгөх өдөр эх хувийг авч очно. |
| МСҮТ ба Дээд боловсрол | МСҮТ -ийн гэрчилгээ (эх хувь) | Улсын болон хувийн хэвшлийн МСҮТ- ээс олгосон гэрчилгээ/гадаадад төгссөн мсүт үүнд хамаарна./ | Хуулбараар бүртгүүлж эх хувийг шалгалт өгөх өдөр авч ирнэ. |
| | Дээд сургуулийн(төгсөх ангид суралцаж буй) диплом | Тухайн сургуулиас олгосон төгсөлтийн диплом (Гадаадын их, дээд сургуулийн дипломыг хүлээн зөвшөөрөхгүй. Аж үйлвэрийн салбарынх хамаарна.) | Хуулбараар бүртгүүлж эх хувийг шалгалт өгөх өдөр авч ирнэ. |
| Улсын мэргэжлийн үнэмлэх | мэргэжлийн үнэмлэх/эх хувь/ эсвэл мэргэжлийн эрхийн тодорхойлолт/эх хувь/ | Улсын мэргэжлийн эрхийн тогтолцооны дагуу албан ёсны шалгалтыг өгч үнэмлэх авсан байна. | Гадаадын эрхийг хүлээн зөвшөөрөхгүй. Хуулбараар бүртгүүлж шалгалт өгөх өдөр эх хувийг авч ирнэ. |

- ❖ БНСУ-д Хөдөлмөр эрхэлж байсан бол тухайн ажлын туршлагыг хүлээн зөвшөөрөх ба ХЭЗОТ-ны (EPS) системээс хэвлэн авдаг ажлын газрын тодорхойлолтийг хүлээн зөвшөөрнө.
- ❖ МСҮТ-ийн гэрчилгээний агуулгад судалсан хичээлийн нэр, кредит цаг, хичээлийн агуулга тусгагдсан байх ёстой.
- ❖ Диплом (Төгсөх ангийн оюутан байж болно) –д тэнхимийн нэр тусгагдсан байна.

Мэргэжлийн ур чадварын үнэлгээнд бүрдүүлж өгсөн бичиг баримтыг хуурамчаар бүрдүүлсэн нь тогтоогдвол тухайн шалгалтыг хүчингүй болгож **шалгалт өгөх эрхийг 4 жилээр хасна.** (Илгээгч байгууллагатай зөвлөлдөж холбогдох хуулийн байгууллагад мэдэгдэх арга хэмжээ авна.)

Дараах ажлын туршлагад МСҮТ (Боловсрол)-ийн гэрчилгээг хүлээн зөвшөөрөхгүй

❖ **(Ажлын туршлага)** Бүртгүүлэгч нь салбар тус бүр (аж үйлдвэр, барилга, газар тариалан ХАА, загас агнуур)-тэй холбоотой компанид ажиллаж байсан ч энгийн худалдаа, менежмент (нягтлан бодох бүртгэл, хүний нөөц г.м) боловсрол, төрийн албан хаагч болон олон нийтийн байгууллагын ажилтан (инженерийн чиглэлээс бусад) үйлчилгээний салбар (хоол, шатахуун түгээх станц, ресторан, үсчин г.м) зэрэг энгийн ажлын туршлагыг мэргэжлийн ур чадварын үнэлгээнд хүлээн зөвшөөрөхгүй.

Зөвхөн боловсролын салбарын туршлагатай бол тухайн салбарын инженер, техниктэй холбоотой боловсрол олгосон бол хүлээн зөвшөөрнө.

Жишээ нь: МСҮТ-ийн байгууллагад тоног төхөөрөмж ашиглалтын багшийн ажил хийж байсан бол хүлээн зөвшөөрнө.

Хүлээн зөвшөөрөхгүй гэрчилгээ гэдэг нь:

- **(Мэргэжлийн эрх)** салбар тус бүртэй холбоогүй мэргэжлийн эрх
Жишээ нь : жолоочийн, гадаад хэлний /багш, эмч, хуульч/ -ийн үнэмлэх, үсчин гоо сайхан, тогоочийн г.м үйлчилгээний салбарын үнэмлэх, дээд сургуулийн диплом г.м
- **(МСҮТ -ийн гэрчилгээ)** боловсролын сургалтын гэрчилгээ нь аж үйлдвэрийн ажилтай холбогдолгүй МСҮТ гэрчилгээтэй байвал
Жич: асран хамгаалагч бэлтгэх дамжаа, ня-бо, менежер удирдагч бэлтгэх дамжаа г.м
- **(Боловсролын гэрчилгээ)** аж үйлдвэрийн салбарын ажил мэргэжилтэй хамааралгүй гэрчилгээ

Улс бүр өөрийн орны онцлогийг харгалзан үзэж илгээгч байгууллагаас хүлээн зөвшөөрөх шалгуураа гаргана. Жишээ нь: Эрүүл мэндийн тэнхим, биеийн тамирын тэнхим, сувилагчийн тэнхим, нягтлан бодох бүртгэлийн тэнхим г.м аж үйлдвэрийн салбартай хамааралгүй тэнхим.

2. 2 дахь шалгалтын мэдээлэл

а. Тов зарлах: 2021 оны 10-р сарын 1-нд

б. Зарлах хэлбэр :

- ① ХХҮЕГ-ын цахим хуудас (hudulmur-halamj.gov.mn)
- ② БНСУ-ын АҮХНХЭГ-ын төлөөлөгчийн газрын цахим хуудас (monkor.net)
- ③ Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцоо СХТТШ-ын цахим хуудас (epstopik.hrdkorea.or.kr)

3. Ур чадварын шалгалт

а. Ур чадварын шалгалтын бүтэц ба онооны хуваарилалт

| Салбар | Нийт оноо | Ур чадварын шалгалт | | |
|------------|-----------|---------------------|-----------|--------------|
| | | Биеийн тамир | Ярилцлага | Суурь чадвар |
| Аж үйлдвэр | 100 | 30 | 30 | 40 |

б. Ур чадварын шалгалтын тов: **2021.10.9-10**-ны өдрүүдэд авна.

- ❖ Шалгалтын хугацаа нь бүртгэлийн дүн(Бүртгүүлсэн иргэдийн тоо)- ээс шалтгаалан өөрчлөгдөж болох тул хүн тус бүрийн шалгалтын хуваарийг 10-р сарын 1-нд зарлана.

в. Ур чадварын шалгалтын тухай

| ангилал | бэлтгэл ажил хангах | шалгалтын заавар өгөх/30мин/ | Шалгалт үргэлжлэх хугацаа/3цаг/ | Үнэлгээ хийж оноо гаргах |
|----------|---------------------|------------------------------|---------------------------------|--------------------------|
| 1-р ээлж | 08:00-08:30 | 08:30-09:00 | 09:00-12:00 | 12:00-12:30 |
| 2-р ээлж | | 12:30-13:00 | 13:00-16:00 | 16:00-17:00 |

- ❖ Батлагдсан шалгалтын өдөр, газрыг өөрчлөх боломжгүй, бичиг баримтаа орхиж ирсэн болон шалгалтын цагаас хоцорч ирсэн бүртгүүлэгчийг шалгалтад оруулах боломжгүй.
- ❖ Ур чадварын шалгалтын үеэр мэргэжлийн ур чадварыг нотлох бичиг баримтыг зэрэгцүүлэн шалгана.

III. Эцсийн хариу зарлах

а. Зарлах өдөр: 2021.10.22

б. СХТТШ ба Ур чадварын шалгалтуудын оноог нийлүүлээд хамгийн өндөр оноо авсан дарааллаар сонгож авахаар тогтоосон тоондоо багтааж авна.

※ Ур чадварын шалгалтын оноо 60 хүрэхгүй бол эцсийн шалгаруулалтанд тэнцэх боломжгүй.

в. Зарлах арга:

- ① ХХҮЕГ-ын цахим хуудас (hudulmur-halamj.gov.mn)
- ② БНСУ-ын АҮХНХЭГ-ын төлөөлөгчийн газрын цахим хуудас (monkor.net)
- ③ Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны СХТТШ-ын цахим хуудас (epstopik.hrdkorea.or.kr)

г. Шалгалтын хүчинтэй хугацаа: Шалгалтад тэнцсэн иргэдийг зарласан өдрөөс хойш 2 жил (2021.10.22-2023.10.21)

IV. Анхаарах зүйлс

1. Өнгө ялгах чадваргүй иргэн шалгаруулалтаас хасагдана. Зөвхөн нурууны үений диск, гарын сарвуу дутуу зэрэг тохиолдолд 2 дахь ур чадварын

шалгалтын комисс ажил хийхэд тохирох эсэхийг шийдвэрлэх бөгөөд ажил хийх чадваргүй гэсэн шийдвэр гарвал сонгон шалгаруулалтаас хасагдана.

2. Шалгалтад гар утас, кассет тоглуулагч, PDA, MP3, электрон толь бичиг зэрэг техник хэрэгсэл авч орж ашиглахыг хориглоно. Хэрвээ эдгээрийг авч орж ашигласан тохиолдолд шалгалтын журам зөрчсөнд тооцно.
3. Бүртгүүлэгч нь хууль бус үйлдэл гаргах тохиолдолд тухайн бүртгүүлэгчийн шалгалтыг хүчингүй болгож Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох тогтолцооны сонгон шалгаруулах шалгалт өгөх эрхийг 4 жилээр хасна. Ялангуяа мэргэжлийн ур чадварыг тодорхойлох бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн тохиолдолд тухайн бүртгүүлэгчийн шалгалтыг хүчингүй болгож, шалгалт өгөх эрхийг 4 жилээр хасна.
4. СХТТШ-ын бүртгэлийн хуудаст дурдсан агуулга (ялангуяа латин үсгээр овог нэрээ бичих, төрсөн он сар өдрөө зөв гаргацтай бичих шаардлагатай), гадаад паспортын мэдээлэлтэй зөрүүтэй бол шалгалтад тэнцсэн ч хөдөлмөрийн биржид нэр байршуулах, БНСУ-д нэвтрэх боломжгүй болно.
5. **Түр нутаг буцсан Е-9 визтэй гадаад ажилтанд дахин ирэх боломж олгоно.**

- 2020 оны 1-р сарын 1-нээс 2020 оны 5-р сарын 6-ны хооронд хилээр нэвтэрч эх орондоо ирсэн байх үед нь БНСУ-д оршин суух хугацаа дууссан иргэн СХТТШ-д тэнцсэн тохиолдолд ур чадварын шалгалт болон явахын өмнөх сургалтаас 1 удаа чөлөөлнө. /шалгуур нь СХТТШ-тай адил байна/
- Түр нутаг буцсан дахин ирэх боломжтой гадаад ажилтан нь хавсралт 3 дахь тодорхойлолт болон холбогдох бичиг баримтыг бүртгэлийн байгууллагад тус тусад нь өгнө.

6. “Ковид-19” цар тахалын халдвараас хамгаалах санамж

- Шалгалтын байранд бусдын аюулгүй байдлыг хангах үүднээс амны хаалт зүүж, шалгалтын комиссын зааврыг дагах;
- Шалгалтад орохоос өмнө халуунаа үзүүлж, гараа ариутгах бөгөөд хэрвээ халуурах, ханиалгах, амьсгалахад бэрхшээлтэй шинж тэмдэг илэрвэл ангид оруулахгүй байх;
- Гар барих, тэврэх зэргээр хүний биед хүрэхгүй байх, ханиаж найтаах бол ханцуйгаараа ам хамраа дарж найтаах соёлтой байх,
- “Ковид-19” цар тахалын халдварын тухайн улсын нөхцөл байдлыг харгалзан үзэж үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөний зарим хэсэгт өөрчлөлт орж болно.

Бусад санамж

- ❖ (БНСУ-ын Хөдөлмөрийн биржид нэр байршуулах) Сонгон шалгаруулалтад тэнцсэн гэдэг нь БНСУ-ын Хөдөлмөрийн биржид нэр байршуулах эрхийг авсан гэсэн үг бөгөөд энэ нь **БНСУ-д Хөдөлмөрийн гэрээгээр явна гэсэн баталгаа болохгүй.**

- ❖ (Эрүүл мэндийн үзлэг шинжилгээ) Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд тэнцээгүй эсвэл урьд өмнө БНСУ-д хууль бусаар амьдарч байсан гэх зэрэг визийн зөрчилтэй бүртгүүлэгч нь илгээх үйл ажиллагаанаас хасагдахыг анхаарна уу.
- ❖ (Хар тамхины сорил) БНСУ-ын хилээр нэвтэрсний дараа хар тамхины сорилд тэнцээгүй иргэн нь нутаг буцна.
- ❖ (Бүртгүүлэгчид тавих шаардлага) БНСУ-д E-9, E-10 визээр 5 болон түүнээс дээш жил ажиллаж амьдарсан бол СХТТШ-д бүртгүүлэх боломжгүй.
- ❖ (Доод оноо) СХТТШ-ын хамгийн доод оноо 50 /нийт 100 оноо байна/ ур чадварын доод оноо 60 /нийт 100 оноо байна/
- ❖ (Мэргэжлийн ур чадварын нэмэлт үнэлгээ) аж үйлдвэрийн салбартай холбоотой ажлын туршлагатай, дээд боловсролтой, техник мэргэжлийн боловсролтой иргэнд нэмэлт оноо өгнө.
- ❖ (мэргэжлийн үнэлгээний бичиг баримт) энэ удаагийн мэргэжлийн ур чадварын бичиг баримтаа тухайн иргэн заавал биеэр авчирч өгнө.
- ❖ (Зүй бус үйлдэл) зүй бус үйлдэл гаргаж хүний оронд шалгалт өгсөн иргэдэд хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, үйлдэл дээрээ баригдсан тохиолдолд тухайн өдрөөс хойш шалгалт өгөх хугацааг 4 жилээр хасна. Хууль бус үйлдэл хийж БНСУ-д ажилд орсон нь баригдвал хуулийн байгууллагад мэдэгдэнэ.

Хавсралт 1

| Суурь чадварын үнэлгээний даалгавар | | | | | |
|-------------------------------------|---|------------------------|--|--|---------|
| Салбар | Төрөл | Үнэлгээний даалгавар | | Үнэлгээний агуулга | Тайлбар |
| Үйлдвэрлэл | Нийт | Нийтлэг | Зүүнүүдийг гараар байршуулах | Ажлын самбарт өнгө, хэлбэр, хэмжээ өөр өөр зүүнүүдийг ялгаж байршуулах | 25 оноо |
| | | Цагирийг рейкэнд өлгөх | Рейкэнд хэмжээ нь өөр цагираг тохирох хэсэгт өлгөх | 25 оноо | |
| | 1. Угсрах (тоног төхөөрөмж, метал, резин) | Онцгой | 1. Угсрах | Өгөгдсөн хугацаанд 2 төрлийн боолт, гайкыг зургийн дагуу угсрах болон тайлах | 50 оноо |
| | 2. Хэмжих (хими, метал, хүнс, мяндас) | Онцгой | 1. Хэмжих (тооцоолох) | Өгөгдсөн хугацаанд хэмжээнд тааруулж хэмжих, тооцоолох | 50 оноо |
| | 3. Холбох | Онцгой | 1. Холбох | Өгөгдсөн хугацаанд олгогдсон багажийг ашиглан заагдсан байршилд дуусгаагүй ажлыг үргэлжлүүлэн хийх болон буулгах | 50 оноо |

【Хавсралт 2】

(Ажлын туршлага, МСҮТ ба Дээд боловсрол, Мэргэжлийн үнэмлэх)

Мэргэжлийн ур чадварын үнэлгээний анкет

| | | | | | | | | | | | | | | | |
|--|--------------------|--|---------------------|---------------|---------------|------------------|------------------|---------------|---------------------|---|--|--|--|--|--|
| Бүртгэлийндугаар. (ХХҮЕГ бөглөнө) | | | | | | | | | | | | | | | |
| Миний бие мэргэжлийн ур чадварын үнэлгээнд ажлын туршлага, мэргэжлийн үнэмлэх зэргийг хуурамчаар бүрдүүлсэн бол иргэний болон эрүүгийн хуульд заасан бүх хариуцлагыг хүлээх болно. * Хурамч бичиг бүрдүүлэх тохиолдолд тухайн шалгалтыг хүчингүй болгож СХТТШөгөх эрхийг 4 жилээр хасна. | | | | | | | | | | | | | | | |
| Бүртгүүлэгч бөглөх хэсэг | | * Хамаарах салбарыг тэмдэглэнэ ү. (●) | | | | | | | | | | | | | |
| СХТТШ-ын бүртгэлийн дугаар | | | | | | | | | | | | | | | |
| Аж үйлдвэр | · угсрах (○) | · хэмжих (○) | · холбох (○) | | | | | | | | | | | | |
| Төрсөн огноо | . . . | Утас. | | | | | | | | | | | | | |
| Бүртгүүлсэн өдөр | 2021. . . | Нэр | (гарын үсэг) | | | | | | | | | | | | |
| Бүртгүүлэгч бөглөх хэсэг | | * хамаарах хэсгийг дугуйлна уу(●) | ХХҮЕГ | | | | | | | | | | | | |
| <input type="checkbox"/> Ажлын туршлага (хамаарах үүн зөвхөн бөглөнө) | | <table border="1"> <tr> <td>Үнэн</td> <td>○</td> </tr> <tr> <td>худал</td> <td>○</td> </tr> </table> | | Үнэн | ○ | худал | ○ | | | | | | | | |
| Үнэн | ○ | | | | | | | | | | | | | | |
| худал | ○ | | | | | | | | | | | | | | |
| <table border="1"> <tr> <td colspan="2">1 жилээс дээш</td> <td colspan="2">1 жилээс доош</td> </tr> <tr> <td colspan="2">○</td> <td colspan="2">○</td> </tr> </table> | | 1 жилээс дээш | | 1 жилээс доош | | ○ | | ○ | | | | | | | |
| 1 жилээс дээш | | 1 жилээс доош | | | | | | | | | | | | | |
| ○ | | ○ | | | | | | | | | | | | | |
| <input type="checkbox"/> МСҮТ ба дээд боловсрол (хамаарах үүн зөвхөн бөглөнө) | | <table border="1"> <tr> <td>Үнэн</td> <td>○</td> </tr> <tr> <td>Худал</td> <td>○</td> </tr> </table> | | Үнэн | ○ | Худал | ○ | | | | | | | | |
| Үнэн | ○ | | | | | | | | | | | | | | |
| Худал | ○ | | | | | | | | | | | | | | |
| <table border="1"> <tr> <td colspan="2">Мэргэжлийн сургалт</td> <td colspan="2">Боловсрол</td> </tr> <tr> <td>120-иос дээш цаг</td> <td>120-иос бага цаг</td> <td>Дээд сургууль</td> <td>Бүрэн дунд сургууль</td> </tr> <tr> <td></td> <td></td> <td></td> <td></td> </tr> </table> | | Мэргэжлийн сургалт | | Боловсрол | | 120-иос дээш цаг | 120-иос бага цаг | Дээд сургууль | Бүрэн дунд сургууль | | | | | | |
| Мэргэжлийн сургалт | | Боловсрол | | | | | | | | | | | | | |
| 120-иос дээш цаг | 120-иос бага цаг | Дээд сургууль | Бүрэн дунд сургууль | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | | | | |
| <input type="checkbox"/> Мэргэжлийн үнэмлэх (хамаарах үүн зөвхөн 2-т багтааж бөглөнө) | | <table border="1"> <tr> <td>үнэн</td> <td>○</td> </tr> <tr> <td>худал</td> <td>○</td> </tr> </table> | | үнэн | ○ | худал | ○ | | | | | | | | |
| үнэн | ○ | | | | | | | | | | | | | | |
| худал | ○ | | | | | | | | | | | | | | |
| <table border="1"> <tr> <td>Д.д</td> <td>Мэргэжлийн үнэмлэх</td> <td>Олгосонон</td> <td>Олгосон газар</td> </tr> <tr> <td>1</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td></td> <td></td> <td></td> </tr> </table> | | Д.д | Мэргэжлийн үнэмлэх | Олгосонон | Олгосон газар | 1 | | | | 2 | | | | | |
| Д.д | Мэргэжлийн үнэмлэх | Олгосонон | Олгосон газар | | | | | | | | | | | | |
| 1 | | | | | | | | | | | | | | | |
| 2 | | | | | | | | | | | | | | | |
| ХХҮЕГ | | Овог нэрName: | (гарын үсэг) | | | | | | | | | | | | |
| Ярилцлагын комисс | | Овог нэр : | (гарын үсэг) | | | | | | | | | | | | |

* Тухайн салбарт ажилласан нийт хугацааг сараар тэмдэглэнэ.

** Тухайн салбарын МСҮТ төгссөн гэрчилгээг шалгасны дараа хичээлийн нийт цагийг бичнэ.

*** Тухайн салбарын боловсрол эзэмшсэн дипломыг шалгасны дараа салбарт хамааралтай эсэхийг шалгаж тэмдэглэнэ.

**** Тухайн салбарын мэргэжлийн үнэмлэхийг шалгасны дараа тухайн салбарт хамаарах үнэмлэхний тоог тэмдэглэнэ.

Маягт 3

Түр хугацаагаар нутаг буцсан дахин БНСУ явах иргэний лавлагаа

Миний бие нь түр нутаг буцаж ирсэн бөгөөд дахин буцахтай холбоотой бичиг баримтыг энэхүү лавлагааны хамт гадаад паспорт, гадаад иргэний үнэмлэхний хуулбарыг бүртгүүлэхээр өгч байгаа бөгөөд эдгээр нь хуурамч тохиолдолд эрүүгийн болон иргэний хуулийн хариуцлага хүлээхээ амлаж байна.

※ Хуурамч бичиг баримт бүрдүүлж өгсөн тохиолдолд тухайн шалгалтыг хүчингүй болгож СХТТШ өгөх эрхийг 4 жилээр хасна.

| | | | |
|------------------------------------|---|---|--------------------------------------|
| Бүртгүүлэгчийн бөглөх хэсэг | | * холбогдох салбарыг дугуйлна (●) | |
| EPS-TOPIK шалгалтын дугаар | | | |
| Аж үйлдвэр | <input type="checkbox"/> ·угсрах (○) | <input type="checkbox"/> ·хэмжих (○) | <input type="checkbox"/> ·холбох (○) |
| Барилга | <input type="checkbox"/> ·арматур (○) | <input type="checkbox"/> ·мужаан (○) | |
| ХАА & Газар тариалан | <input type="checkbox"/> ·жимс ногоо тарих (○) | <input type="checkbox"/> ·мал аж ахуй (○) | |
| Загас агнуур | <input type="checkbox"/> ·үржүүлгийн агнуур (○) | <input type="checkbox"/> ·далайн агнуур (○) | |

| | | | |
|---|---------------|--|--------------|
| Төрсөн огноо | . . . | Утасны дугаар | |
| Оршин суусан хугацаа | . . . ~ . . . | Хилээр гарсан өдөр | . . . |
| Хуучин гадаад паспорт бүртгүүлсэн өдөр | . . . | Шинэ гадаад паспорт Овог нэр гарын үсэг | (гарын үсэг) |

Шалгасан : Илгээх байгууллага **Овог нэр :** (гарын үсэг)

Шалгасан : И Пи Эс ТӨВ **Овог нэр :** (гарын үсэг)

* Хавсаргах материал : оршин суух хугацаа хилээр гарсан өдрийг шалгаж болох гадаад иргэний үнэмлэх ба гадаад паспортын хуулбар